



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.07.05 № 05/5604  
танай 2019.07.01 -ны № 01/2044 -т

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ДЭД ДАРГА  
Б.ЗАЯАБАЛ ТАНАА

*ВУГ*  
*00 2019/7/18*

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянасан тухай

Татварын ерөнхий газрын Татварын удирдлага, хамтын ажиллагааны газарт татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Цэдэнбалын Одончимэг, Хуулийн хэрэгжилтийг хангах газарт татварын улсын ахлах байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Шаалуугийн Цогзолмаа, Хан-Уул дүүргийн Татварын хэлтсийн татвар төлөгчтэй харилцах тасагт татварын улсын байцаагчаар томилогдохоор нэр дэвшсэн Баянбатын Чаминчулуун нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлэх үүрэгтэй болохыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ,  
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

*Х.ХАШБААТАР*

